

БАТЛАВ:  
ЭРҮҮЛ МЭНДИЙН ХӨГЖЛИЙН ТӨВИЙН  
ЗАХИРАЛ *Ц.Бат-Эрдэнэ* Ц.БАТ-ЭРДЭНЭ

**ЭЙЧ ИНФО 3 ПРОГРАМЫГ ХӨГЖҮҮЛЭХ ТӨСЛИЙН  
ПРОГРАММИСТТАЙ ХИЙХ АЖЛЫН ГЭРЭЭ**

2016 оны 11 дугаар сарын 21- ний өдөр

Улаанбаатар хот

2016 0 / 0112 II

**1. Нийтлэг үндэслэл**

1.1. Энэхүү гэрээ нэг талаас захиалагч Эрүүл мэндийн хөгжлийн төв /цаашид 'Захиалагч' гэх/-ийг төлөөлж Захиргаа, аж ахуйн албаны дарга Л.Оюунчимэг, нөгөө талаас ЛЮ91030816 тоот регистрийн дугаартай Нацагдорж Наранхүү /цаашид 'Төслийн программист' гэх/ нар Эйч Инфо 3 програмын системийн шинжилгээг хийж, програм хөгжүүлэлт хийж хүлээлгэн өгөх, баталгаат үйлчилгээг гүйцэтгэхээр харилцан тохиролцож байгуулав.

1.2 Гэрээ нь Монгол Улсын Иргэний хууль болон бусад холбогдох хууль журам, ДЭМБ—тай байгуулсан гэрээг удирдлага болгон хамтран ажиллаж эрх үүрэг, гүйцэтгэлийн үр дүнтэй холбоотой харилцааг зохицуулна.

1.3. Захиалагч, Төслийн программист нь хамтран ажиллах, эрх тэгш байх, харилцан ашигтай байх, гүйцэтгэлийн үр дүнтэй байх зарчмыг баримтлан ажиллана.

1.4. Гэрээ нь 2016 оны 11 дугаар сарын 21-наас эхлэн 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрийг хүртэлх хугацаанд хавсралтаар батлагдсан ажил, үүргийг хийж гүйцэтгэнэ.

1.5. Төслийн программистаар ажиллагчийн нийгмийн даатгалын шимтгэл, ажлын цагийн горимыг Монгол Улсын Хөдөлмөрийн тухай хуульд заасны дагуу шийдвэрлэнэ.

**2. Захиалагчийн хүлээх эрх, үүрэг**

2.1. Төслийн программист дараах ажил, үүрэг гүйцэтгүүлнэ. Үүнд:

- Програмыг шинэчлэх, гарын авлага гаргах
- Модулийг нэгтгэн зураглал гаргах, гарын авлага гаргах
- Программ бичих, гарын авлага гаргах
- Шинэ H-info туршсан үр дүнгийн гарын авлага гаргах

2.2. Ажил гүйцэтгэгчид, үүргээ гүйцэтгэх өрөө тасалгаа, ширээ, сандал бусад шаардлагатай техник хэрэгслээр хангана.

2.3. Энэхүү гэрээнд заасан ажил гүйцэтгүүлэхийн тулд ажлын хөлсийг сард 1.100.000 төгрөгөөр тооцож сар тутамд олгоно

2.4. Төслийн программист нь программыг хөгжүүлж код бичих ажлыг төслийн Зөвлөхөөс гаргасан төлөвлөгөө, удирдамжийн дагуу хийж гүйцэтгэнэ.

2.5. Захиалагч нь Төслийн программистын буруутай үйл ажиллагааны улмаас учруулсан аливаа хохирлыг нөхөн төлүүлэх, засварлуулах эрхтэй.

2.6. Төслийн программист нь гэрээгээр гүйцэтгэх захиалгат ажлыг биелүүлээгүй, албан ёсоор чөлөө аваагүй болон хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр ажлаа орхисон тохиолдолд олгосон цалин бусад санхүүжилтийг 1.5 дахин нэмэгдүүлэн буцаан төлж барагдуулна.

### **3. Ажил гүйцэтгэгчийн хүлээх эрх, үүрэг**

3.1. Эрүүл мэндийн хөгжлийн төвийн захиалсан ажил үүргийг гэрээгээр тохиролцсон хугацаанд захиалагчийн өгсөн даалгавар, захиалгын дагуу бүрэн чанартай гүйцэтгэнэ.

3.2. Ажлын цагийн горим, хөдөлмөрийн дотоод журмыг баримтлан ажиллана.

3.3. Төслийн программист нь 2 долоо хоногт нэг удаа тухайн хугацаанд хийсэн ажлыг СТСМА-ны дарга Ч. Зулцэцэг, МТЭТТА-ны дарга С.Солонго нарт тогтмол танилцуулна. Төслийн ажлын явцад шаардлагатай тохиолдолд системийн шаардлагад ороогүй боловч нэн шаардлагатай ажлыг тухай бүрт нь гүйцэтгэх, Захиалагчтай зөвлөлдөх эрхтэй.

3.4. Гэрээнд заасан нөхцөлөөр хангахыг захиалагчаас шаардах, захиалагчийн буруугаас үүсэн аливаа асуудлыг хүсэлт тавин шийдвэрлүүлэх, гэрээнд заасан ажлыг гүйцэтгэх боломжгүй тохиолдолд захиалагч талд урьдчилан мэдэгдэж тохиролцон, шаардлагатай гэж үзвэл ажлыг гүйцэтгэхээс татгалзах эрхтэй.

### **4. Гэрээг дүгнэх журам, хариуцлага**

4.1. Энэхүү гэрээний 2.1.-д заасан чиглэлээр ажил үүргээ биелүүлж, холбогдох ажилтан, албан хаагч нарт тайлангаа хүлээлгэн өгсөн тохиолдолд биелэгдсэн гэж үзэж,

ажлын 2 хоногийн дотор хөлсөөр ажилласны төлбөрийг Худалдаа Хөгжлийн банкны 463007026 тоот сар бүрийн 15- нд болон 30- нд дансанд шилжүүлж олгоно.

4.2. Гэрээний биелэлтийг Захиргаа, аж ахуйн албаны дарга Л.Оюунчимэг, мэргэжилтэн Г.Батцэцэг, төслийн багийн зохицуулагч Д. Мөнхзул нар харилцан дүгнэж протокол үйлдэнэ.

4.3. Энэхүү гэрээтэй холбоотой маргааныг эвийн журмаар шийдвэрлэх бөгөөд, тохиролцоогүй тохиолдолд шүүхэд хандаж шийдвэрлүүлнэ.

4.4. Бусад хариуцлага: Аль нэг талын буруутай үйл ажиллагааны улмаас гарсан зардлыг буруутай тал нь нөхөн төлнө.

### 5. Тав. Бусад зүйл

5.1. Талдууд аль нэг талын зөвшөөрөлгүйгээр гуравдагч этгээдэд аливаа нууц мэдээллийг задруулахыг хориглоно.

5.2. Талуудын хооронд шилжүүлэн өгсөн нууцын зэрэглэлд хамаарах мэдээлэл, баримт бичигтэй Захиалагч, Төслийн программист зөвхөн гэрээний дагуу хийж буй ажилтай шууд холбоо бүхий хүмүүс танилцаж болно.

5.3. Талууд давагдашгүй хүчин зүйлийн (тухайлбал: газар хөдлөлт, үер, гал түймэр, халдварт өвчний тархалт болон бусад аюултай үзэгдэл, ажил хаялт, төрийн шийдвэр, оролцоо гэх мэт) улмаас гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэх боломжгүй болсон тохиолдолд гэрээний хариуцлагаас чөлөөлөгдөх үндэслэл болно.

### 5. Талуудын хаяг

#### Захиалагч:

Нэр, албан тушаал:

\_\_\_\_\_

Утас:

\_\_\_\_\_

#### Гүйцэтгэгч:

Нэр, хаяг:

БЗД 12-р хороо 20 байр 39 тоот

Н. Наранхүү *Н. Наранхүү*

Утас: 80291015, 99115852/ах/

\_\_\_\_\_